



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Ажил зохион байгуулах тухай

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч О.Ганбаатарын 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02/665 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангах зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Рашаант, Хужирын хяр, Дааган толгой, Эмээлт хэсгийн хур хогийн цэгийг цэвэрлэхэд шаардагдах зардалд хөрөнгийн дэмжлэг үзүүлж, ажил гүйцэтгүүлэх 3 талт гэрээг Дүүргийн Засаг дарга, гүйцэтгэгч байгууллагатай байгуулах ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Хур хогийн цэгийг цэвэрлэсний дараагаар дахин хог хаягдал үүсгэхгүй байх, тус газарт газар эзэмших захирамж гаргах ажлыг зохион байгуулахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Г.ГАНТӨМӨР



D:\backup\_old\_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300279